



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 4/05

Булган сум

“Код бичих” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV дүгээр хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Код бичих” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Б.Батбаяр (Аймгийн Засаг даргын Эрүүл мэндийн асуудал хариуцсан зөвлөх)
Б.Мягмаржаргал (Аймгийн Засаг даргын зөвлөх)
М.Солонго (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Б.Солонгомаа (Боловсролын газрын Статистик мэдээ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч)
Ж.Орхонтуул (Боловсролын газрын Дүрслэх урлаг, зураг зүй, технологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч)
Э.Мөнх-очир (Ерөнхий боловсролын III сургуулийн физик, мэдээлэл технологийн багш)

Нарийн бичгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

2. “Код бичих” хөтөлбөрийг хууль журмын дагуу оновчтой боловсруулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж, 2025 оны I улиралд батлуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР

Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010225